



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>


2021. 03. 31 № 01/772

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗАРТ**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт 43 хуудастай.



d:\уухүя 2021 Сайда а5.docx  
000 080567



УУЛ УУРХАЙ, ХҮНД  
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**2020 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН ТАЙЛАН**





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Одхүү хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох журмаар тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2020 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” зэргийг тус тус баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн санхүүжилтээр салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бусад мэдээ, баримт бичиг, материалд тулгуурлан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 3 багц, 8 үзүүлэлтээр дүгнэв.

Сангийн яамнаас нэгтгэн гаргадаг Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг үнэлгээнд оруулав.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2020 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээ **84.7%** буюу **4.24** оноотой байна.

Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засагт 2020 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 22%, гадаадын шууд хөрөнгө оруулалт 72%, аж үйлдвэрийн салбар 71%, нийт экспортын 94%-ийг эзэлж улсын төсөвт 2.6 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллаа. 2020 онд хийж хэрэгжүүлсэн томоохон ажлуудыг дурдвал:

- Монгол Улсын Их Хурлаар 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлнө” гэж заасны дагуу 6 сая хүртэлх тэтгэврийн зээлтэй 207.5 мянган иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийг Салхитын мөнгө, алтны ордоос төлөв.
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 тоот тогтоолоор компанийн нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг олгохоор тооцон 2,512,768 хувьцаа эзэмшигч



иргэдэд 179.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор анх удаа шийдвэрлэлээ. Тус компани үйл ажиллагааны үр дүнгээр 1.0 /нэг/ их наяд төгрөгийг ашигтай ажилласан анхны компаниар бүртгэгдлээ.

- Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хуралдаанаас “Улсын хэмжээнд бүх айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл төр бүрэн хариуцахаар” шийдвэрлэсний дагуу шаардлагатай 650 орчим тэрбум төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ санхүүжүүлэн ажиллаж байна.
- “Алт-2” үндэсний хөтөлбөр амжилттай хэрэгжиж Монгол Улсын түүхэнд анх удаа 23569.1 кг алтыг Монгол банкинд тушааж улсын эрдэнэсийн санг арвижуулсан байна.

**1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН**

**1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2020 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим системд байршуулсан нийт 151 шийдвэрийн 247 зүйл, заалтыг доор дурдсан агуулгаар ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг 90.3 хувийн биелэлттэйгээр дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 17 шийдвэрийн 27 зүйл, заалтын хэрэгжилт - 94.1%;
- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 22 шийдвэрийн 30 зүйл, заалтын хэрэгжилт - 94.0%;
- Уул уурхайн бодлогын 66 шийдвэрийн 105 зүйл, заалтын хэрэгжилт - 88.3%;
- Хүнд үйлдвэрийн бодлогын 8 шийдвэрийн 9 зүйл, заалтын хэрэгжилт - 77.7%;
- Нийтлэг асуудлын 38 шийдвэрийн 76 зүйл, заалтын хэрэгжилт - 91.3%-ийн тус тус биелэлттэй байна.

**ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ**

| №               | Ангилал  | /Салбараар/ |            |             |
|-----------------|--|-------------|------------|-------------|
|                 |  | Шийдвэр     | Заалт      | Үнэлгээ %/  |
| 1               | Геологи, эрдэс баялгийн бодлого  | 17          | 27         | 94.1        |
| 2               | Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого | 22          | 30         | 94.0        |
| 3               | Уул уурхайн бодлого  | 66          | 105        | 88.3        |
| 4               | Хүнд үйлдвэрийн бодлого  | 8           | 9          | 77.7        |
| 5               | Нийтлэг асуудлын   | 38          | 76         | 91.3        |
| <b>Нийт дүн</b> |  | <b>151</b>  | <b>247</b> | <b>90.3</b> |

Нийт 151 шийдвэрийн 247 зүйл, заалтын 17 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 230 зүйл, заалтын 177 зүйл, заалт буюу 76.9% нь “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 37 зүйл, заалт буюу 16.1% нь “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 16 зүйл, заалт буюу 6.9% нь “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй байна.

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

/2020 оны жилийн эцэс/

/Төрлөөр/

| Хууль тогтоомж, тогтоол шийдвэр  | Бүгд | /Төрлөөр/   |                |                                |                       |                             |               |                |                            |                                |
|----------------------------------|------|-------------|----------------|--------------------------------|-----------------------|-----------------------------|---------------|----------------|----------------------------|--------------------------------|
|                                  |      | МУ-ын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | ЗГ-ын тогтоол | ЕС-ын захирамж | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар |
| Хяналтад авагдсан шийдвэрийн тоо | 151  | 11          | 12             | 9                              | 1                     | 3                           | 59            | 7              | 47                         | 2                              |
| Заалтын тоо                      | 247  | 26          | 26             | 12                             | 1                     | 3                           | 93            | 7              | 67                         | 15                             |



## УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан

|                |                            |             |             |             |              |              |             |             |             |             |   |
|----------------|----------------------------|-------------|-------------|-------------|--------------|--------------|-------------|-------------|-------------|-------------|---|
| Үүнээс         | Биелсэн 100%               | 177         | 19          | 16          | 10           | 1            | 3           | 67          | 4           | 50          | 7 |
|                | Хэрэгжих шатанд 70.0%      | 37          | 3           | 5           | 2            | 0            | 0           | 12          | 2           | 8           | 5 |
|                | Хэрэгжилт хангалтгүй 30.0% | 16          | 4           | 4           | 0            | 0            | 0           | 5           | 0           | 1           | 2 |
|                | Хэрэгжээгүй 0%             | 0           | 0           | 0           | 0            | 0            | 0           | 0           | 0           | 0           | 0 |
|                | Дүгнэгдээгүй               | 17          | 0           | 1           | 0            | 0            | 0           | 9           | 1           | 5           | 1 |
| <b>Үнэлгээ</b> | <b>90.3</b>                | <b>85.3</b> | <b>82.8</b> | <b>95.0</b> | <b>100.0</b> | <b>100.0</b> | <b>91.5</b> | <b>90.0</b> | <b>94.5</b> | <b>79.3</b> |   |

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 11 хуулийн 26 заалтын хэрэгжилт - 85.8%;
- УИХ-ын 12 тогтоолын 26 заалтын хэрэгжилт - 82.8%;
- УИХ-ын Байнгын хорооны 9 тогтоолын 12 заалтын хэрэгжилт - 95.0%;
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалтын хэрэгжилт - 100.0%;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт - 100.0%;
- Засгийн газрын 59 тогтоолын 93 заалтын хэрэгжилт - 91.5%;
- Ерөнхий сайдын 7 захирамжийн 7 заалтын хэрэгжилт - 90.0%;
- Засгийн газрын хуралдааны 47 тэмдэглэлийн 64 заалтын хэрэгжилт - 94.7%;
- Засгийн газрын 2 албан даалгаврын 15 заалтын хэрэгжилт - 79.3% байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулан, тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/121 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) сайтад байршуулж баталгаажуулав.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8.6-д заасны дагуу цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, бүрэн хэрэгжсэн, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан нийт 38 шийдвэрийн 76 зүйл, заалтыг хяналтаас хасуулах саналыг тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллав.

### 1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан, 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим системд байршуулсан 17 зорилтын 72 арга хэмжээний хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналтад авагдсан 72 арга хэмжээний 42 арга хэмжээг яам толгойлон, 30 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба нийт 72 арга хэмжээний биелэлт **50.3%**-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 90.0 хувь;



## УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан

- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 66 арга хэмжээний биелэлт 48.4 хувь;
- Засаглалын бодлогын хүрээний 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 70.0 хувь;
- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 60.0 хувь, хэрэгжүүлсэн нийт **72** арга хэмжээний биелэлтийг **50.3** хувьтай дүгнэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/234 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) сайтад байршуулж баталгаажуулав.

### ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО /2020 оны жилийн эцэс/

| Зорилт   | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо |           |           |           |          | Хэрэгжилт /хувь/ |
|--|--------------|--------------------|---------------------------------------|-----------|-----------|-----------|----------|------------------|
|  |              |                    | 90                                    | 70        | 50        | 30        | 0        |                  |
| Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого | 1            | 1                  | 1                                     | 0         | 0         | 0         | 0        | 90.0             |
| Хоёр. Эдийн засгийн бодлого  | 11           | 66                 | 10                                    | 13        | 14        | 23        | 6        | 48.4             |
| Дөрөв. Засаглалын бодлого  | 3            | 3                  | 1                                     | 1         | 1         | 0         | 0        | 70.0             |
| Тав. Ногоон хөгжлийн бодлого   | 2            | 2                  | 1                                     | 0         | 0         | 1         | 0        | 60.0             |
| <b>Дүн</b>   | <b>17</b>    | <b>72</b>          | <b>13</b>                             | <b>14</b> | <b>15</b> | <b>24</b> | <b>6</b> | <b>50.3</b>      |

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг 2020 оны жилийн эцсийн байдлаар **50.3** хувьтай дүгнэснээс 13 арга хэмжээ үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 14 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 15 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 24 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, 6 арга хэмжээ хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй буюу 0 хувийн хэрэгжилттэй байна.

**Хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй буюу 0 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ байна. Үүнд:**

1. 3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ зорилтын 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах;
2. 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ зорилтын 2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна;



3. 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ зорилтын 6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна;
4. 3.6.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ зорилтын 2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна;
5. 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ зорилтын 1. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна;
6. 3.7.13 Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ зорилтын 3. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

### **1.3. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан “Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого”-ын “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.” зорилтын 4 арга хэмжээ, 14 шалгуур үзүүлэлтийг дангаар хэрэгжүүлэн ажиллав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тус яамны “дангаар” хэрэгжүүлсэн 1 зорилтын 4 арга хэмжээ, 14 шалгуур үзүүлэлтийн биелэлт “тодорхой үр дүнд хүрсэн” **73.57** хувьтай, үүнээс 7 шалгуур үзүүлэлт нь 90 хувь, 3 шалгуур үзүүлэлт нь 70 хувь, 4 шалгуур үзүүлэлт нь 30 хувьтай байна.

#### **МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ (2020 оны жилийн эцэс)**

| №  | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт, хувиар |    |    |    |   | Биелэлт /хувиар/ 206 дугаар журам |
|--|-------------|------------------|--------------------------------|----|----|----|---|-----------------------------------|
|  |             |                  | 90                             | 70 | 50 | 30 | 0 |                                   |
| <b>ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО</b>  |             |                  |                                |    |    |    |   |                                   |
| Зорилт 5. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ. |             |                  |                                |    |    |    |   |                                   |



|   |  |           |          |          |          |          |          |              |
|---|--|-----------|----------|----------|----------|----------|----------|--------------|
| 5.10  | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх   | 6         | 5        | 1        | 0        | 0        | 0        | 86.67        |
| 5.20  | Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх  | 2         | 2        | 0        | 0        | 0        | 0        | 90.00        |
| 5.30  | Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх   | 5         | 0        | 1        | 0        | 4        | 0        | 38.00        |
| 5.4.  | Газрын тосны бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулж, Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх | 1         | 0        | 1        | 0        | 0        | 0        | 70.00        |
| <b>Арга хэмжээний тоо болон биелэлт, хувиар</b> |  | <b>14</b> | <b>7</b> | <b>3</b> | <b>0</b> | <b>4</b> | <b>0</b> | <b>73.57</b> |

Үндсэн чиглэлийн зорилтот түвшиндээ хүрээгүй, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа, тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй 4 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

**“Эрчимжүүлэх шаардлагатай” 30 хувийн биелэлттэй 4 шалгуур үзүүлэлт:**

1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар;
2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах шугам хоолойн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах, ажлын явц, хувиар;
3. Нүүрс угаах, гүн боловсруулах/Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих/ үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар;
4. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр болон Төмөртэйн ордын баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлын явц, хувиар зэрэг болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/161 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) сайтад байршуулж баталгаажуулав.

#### **1.4. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2018 оны “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай” 55 дугаар тогтоолыг тус тус удирдлага болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны



## УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан

бүтээгдэхүүний импорт, металл, шатах ашигт малтмалын үйлдвэрлэлийн 9 ангиллын 19 үзүүлэлтийг Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан. Эдгээрээс тайлант хугацаанд 7 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн буюу давж биелсэн бол үлдсэн 12 үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, үзүүлэлт буурсан гүйцэтгэлтэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар “тодорхой үр дүнд хүрсэн” буюу **74.83** хувьтай, **3.74** оноогоор дүгнэгдлээ.

### УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

/2020 оны жилийн эцэс/

| № | Үзүүлэлт   | Суурь үзүүлэлт /2016/ | Эхний жил /2017 он/ |               | 2 дахь жил /2018 он/ |               | 3 дахь жил /2019 он/ |               | 4 дэх жил /2020 он/ |               |          |         |      |
|---|--|-----------------------|---------------------|---------------|----------------------|---------------|----------------------|---------------|---------------------|---------------|----------|---------|------|
|   |  |                       | Зорилтот түвшин     | Хүрсэн түвшин | Зорилтот түвшин      | Хүрсэн түвшин | Зорилтот түвшин      | Хүрсэн түвшин | Зорилтот түвшин     | Хүрсэн түвшин | Өөрчлөлт | Үнэлгээ |      |
|   |  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          | Хувь    | Оноо |
| 1 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)                     | 34.6                  | 37.0                | 37.4          | 38.4                 | 38.7          | 41.0                 | 43.50         | 41.0                | 41.06         | 0.06     | 100     | 5.0  |
| 2 | Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг зохиох төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх) | 86.0                  | 100.0               | 100.0         | 100.0                | 92.1          | 92.0                 | 94.00         | 100.0               | 92.11         | -7.89    | 92      | 4.6  |
| 3 | <b>Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ</b>  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          |         |      |
|   | Газрын тос (мянган баррель)  | 8,249.8               | 7,971.1             | 7,632.6       | 10,850.7             | 6,188.4       | 10,899.1             | 6,875.5       | 10,899.1            | 4,082.2       | -6,816.9 | 37.5    | 1.9  |
|   | Нүүрс (сая тонн)   | 35.4                  | 47.1                | 47.1          | 37.0                 | 50.0          | 41.1                 | 50.8          | 41.1                | 43.1          | 2.0      | 104.8   | 5.0  |
|   | Зэсийн баяжмал (мянган тонн)   | 1,445.1               | 1,310.0             | 1,317.1       | 1,500.0              | 1,310.8       | 1,820.0              | 1,262.4       | 1,920.0             | 1,275.7       | -644.3   | 66.4    | 3.3  |
|   | Төмрийн хүдэр (сая тонн)   | 4.9                   | 10.0                | 7.7           | 10.0                 | 6.2           | 10.0                 | 12.0          | 10.0                | 9.2           | -0.8     | 92.0    | 4.6  |
|   | Алт (тонн)   | 18.4                  | 19.8                | 19.8          | 20.0                 | 21.9          | 23.0                 | 16.3          | 23.0                | 23.6          | 0.6      | 102.5   | 5.0  |
| 4 | <b>Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ</b>  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          |         |      |
|   | Газрын тос (мянган баррель)  | 8,015.9               | 7,100.0             | 7,514.2       | 10,100.0             | 6,389.0       | 10,100.0             | 6,546.6       | 10,100.0            | 4,070.5       | -6,029.5 | 40.3    | 2.0  |
|   | Нүүрс (сая тонн)   | 25.7                  | 33.4                | 33.0          | 25.5                 | 35.8          | 28.0                 | 36.6          | 28.0                | 28.7          | 0.7      | 102.4   | 5.0  |
|   | Зэсийн баяжмал (мянган тонн)   | 1,562.0               | 1,280.0             | 1,447.2       | 1,620.0              | 1,436.7       | 1,720.0              | 1,403.6       | 1,720.0             | 1,395.1       | -324.9   | 81.1    | 4.1  |
|   | Төмрийн хүдэр (сая тонн)   | 6.1                   | 6.2                 | 6.3           | 10.0                 | 7.4           | 10.0                 | 12.0          | 10.0                | 8.2           | -1.8     | 82.0    | 4.1  |
|   | Алт (тонн)   | 19.2                  | 15.0                | 14.6          | 15.0                 | 3.4           | 15.0                 | 9.1           | 15.0                | 30.5          | 15.5     | 203.3   | 5.0  |
| 5 | <b>Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ (сая тонн)</b>  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          |         |      |
|   | Үүнээс: ОХУ-аас  | 1.22                  | 1.49                | 1.50          | 1.40                 | 1.79          | 1.50                 | 2.00          | 1.50                | 1.95          | 0.45     | 130.0   | 5.0  |
|   | Бусад улсаас   | 1.16                  | 1.44                | 1.46          | 1.30                 | 1.79          | 1.30                 | 1.90          | 1.30                | 1.81          | 0.51     | 139.3   | 5.0  |
|   | Бусад улсаас   | 0.06                  | 0.05                | 0.04          | 0.10                 | 0.08          | 0.20                 | 0.18          | 0.20                | 0.13          | -0.07    | 66.5    | 3.3  |
| 6 | <b>Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл (мян. тн)</b>  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          |         |      |
|   | Дизель түлш  | 30.0                  | 30.0                | 32.0          | 30.0                 | 29.0          | 30.0                 | 98.9          | 30.0                | 2.3           | -27.7    | 8.0     | 0.4  |
|   | Автобензин   | 15.0                  | 15.0                | 20.0          | 15.0                 | 3.5           | 30.0                 | 8.8           | 30.0                | 0.0           | -30.0    | 0.0     | 0.0  |
|   | Мазут  | 5.0                   | 5.0                 | 10.0          | 5.0                  | 3.5           | 10.0                 | 0.4           | 10.0                | 1.2           | -8.8     | 12.0    | 0.6  |



## УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан

|   |                                    |      |      |      |      |      |       |      |       |      |       |              |             |
|---|------------------------------------|------|------|------|------|------|-------|------|-------|------|-------|--------------|-------------|
| 7   | Ган бүтээгдэхүүн<br>(мянган тонн)  | 40.0 | 50.0 | 60.0 | 50.0 | 70.1 | 50.0  | 75.0 | 50.0  | 64.8 | 14.8  | 129.6        | 5.0         |
| 8   | Катодын зэс<br>(мянган тонн)       | 15.0 | 15.0 | 14.7 | 15.0 | 14.2 | 25.0  | 11.7 | 25.0  | 9.5  | -15.7 | 38.0         | 1.9         |
| 9   | Ангилуулсан төмөр<br>(мянган тонн) | /-/  | /-/  | /-/  | /-/  | /-/  | 500.0 | 0.0  | 500.0 | 0    | -500  | 0.0          | 0.0         |
| <b>УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн<br/>ерөнхий үнэлгээ</b> |                                    |      |      |      |      |      |       |      |       |      |       | <b>74.83</b> | <b>3.74</b> |

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

## 2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1. БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2020 онд 24 зорилтын хүрээнд нийт 75 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлснээс төлөвлөгөөний биелэлт, хүрсэн түвшинд хийсэн үнэлгээгээр 75 арга хэмжээний гүйцэтгэлийг **98.4%**-тай дүгнэв.

#### БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Хувиар/

| №           | Дэд салбар   | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэлийн үнэлгээ, хувиар |          |          |          |          |          | Дундаж хувь  |
|-------------|--|--------------|--------------------|------------------------------|----------|----------|----------|----------|----------|--------------|
|             |  |              |                    | 100                          | 90       | 70       | 50       | 30       | 0        |              |
| 1.          | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт   | 6            | 23                 | 18                           | 3        | 2        | 0        | 0        | 0        | 96.1%        |
| 2.          | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилт                             | 1            | 4                  | 4                            | 0        | 0        | 0        | 0        | 0        | 100%         |
| 3.          | Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт /хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг/ | 13           | 31                 | 30                           | 0        | 1        | 0        | 0        | 0        | 99%          |
| 4.          | Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт /хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг/   | 4            | 17                 | 17                           | 0        | 0        | 0        | 0        | 0        | 100%         |
| <b>Нийт</b> |  | <b>24</b>    | <b>75</b>          | <b>69</b>                    | <b>3</b> | <b>3</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>98.4%</b> |

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийтдээ 75 арга хэмжээ төлөвлөснөөс үнэлгээ өгсөн 75 арга хэмжээний биелэлт **98.4%**-тай байна.

Хэрэгжүүлсэн 75 арга хэмжээний 69 /95.7%/ нь тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, 6 арга хэмжээ /4.1%/ нь тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, яамнаас хамаарах шийдвэр гарсан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байна.

### 2.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан.

Тус журмын 6 дугаар хэсэгт заасны дагуу хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх 3 зорилтын 8 үйл ажиллагаа, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 4 зорилтын 6 үйл ажиллагаа, нийт 12 шалгуур үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээ өгөв.



**УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан**

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 100%-тай дүгнэв.

Яамны 2020 оны төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулах, хоол унааны нэмэгдлийн төсвийг батлуулж хэрэгжүүлсэн байна.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ /2020 оны жилийн эцэс/**

| №   | Үйл ажиллагаа  | №           | Шалгуур үзүүлэлт                              | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин         | Тайлбар   | Үнэлгээ |
|---|--|-------------|---|-----------------|-----------------------|---|---------|
| <b>Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх</b> |  |             |   |                 |                       |   |         |
| 1   | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1         | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:       | 0               | 75                    | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны сургалтын төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 10 нд Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | 100     |
|   |  | Үүнээс      | Ажлын байран дахь сургалт                     | 0               | 28                    |   |         |
|   |  |             | Мэргэшүүлэх сургалт                           | 0               | 5                     |   |         |
|   |  |             | Туршлага солилцох арга хэмжээ                 | 0               | 0                     |   |         |
|   |  |             | Бусад   | 0               | 47                    |   |         |
|   |  | 1.2.        | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:           | 0               | 78                    |   | 100     |
|   |  | Үүнээс      | Эмэгтэй албан хаагч                           | 0               | 12                    |   |         |
|   |  |             | Эрэгтэй албан хаагч                           | 0               | 36                    |   |         |
|   |  |             | Удирдах албан тушаалтан                       | 0               | 19                    |   |         |
|   |  |             | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан             | 0               | 29                    |   |         |
| 1.3.  | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь   | 90-ээс дээш | 78 хүн давхардсан тоогоор                     | 100             |                       |   |         |
| 2   | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт                  | 2.1.        | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | -               | 1 хүн 10.7 сая төгрөг | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал, "Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм,        | /-/     |
|   |  | 2.2.        | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:           | -               | -                     |   | /-/     |
|   |  | Үүнээс      | Эмэгтэй албан хаагч                           | -               | -                     |   |         |



**УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан**

|   |   |      |  |             |                                    |   |            |
|---|---|------|--|-------------|------------------------------------|---|------------|
|   |   |      | Эрэгтэй албан хаагч  | -           | -                                  | эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль болон Улсын онцгой комиссын шийдвэр, хэмнэлтийн горимд ажиллах шийдвэрээс шалтгаалан гадаад сургалтанд хамрагдаагүй. |            |
|   |   |      | Удирдах албан тушаалтан  | -           | -                                  |   |            |
|   |   |      | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан  | -           | -                                  |   |            |
|   |   | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь                           | 20-оос дээш | -                                  |   | /-/        |
| 3   | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)         | -           | 11.1                               |   | 100        |
|   |   | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь  | 15-аас доош | Шилжсэн 3                          |   | 100        |
| <b>Үнэлгээний дүн</b>                           |   |      |  |             |                                    |   | <b>100</b> |
| <b>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах</b> |   |      |  |             |                                    |   |            |
| 4   | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх  | 4.1  | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь            | -           | 47,5 хувь                          | ТНБД-ын 2020 оны 11 дүгээр сарын 4-ны өдрийн А/118 дугаар тушаалаар өөрчлөн баталсан.   | 100        |
|   |   | 4.2  | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)                                     | -           | Хоногт хоол 8000, унаа 4000 төгрөг |   | 100        |
| 5   | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх  | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 80-аас дээш | Ханамжтай                          | 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ямар нэгэн өргөдөл, гомдол гараагүй.  | 100        |
| 6   | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх   | 6.1  | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)   | 1-ээс дээш  | 1 удаа                             | Сөүл эмнэлэг 2020 оны 12 дугаар сард  | 100        |
|   |   | 6.2  | Албан хаагчдын хамрагдалт  | 90-ээс дээш | Нийт 78 албан хаагч                |   | 100        |

**УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан**

|                            |  |     |  |   |       |   |            |
|----------------------------|--|-----|--|---|-------|---|------------|
| 7                          | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1 | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | - | 165.2 | Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар хэсгийн 6.1.2-6.1.4 хүртэл | 100        |
| <b>Үнэлгээний дүн</b>      |  |     |  |   |       |   | <b>100</b> |
| <b>Үнэлгээний нийт дүн</b> |  |     |  |   |       |   | <b>100</b> |

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг хавсаргав.

### 3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

#### 3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолын хавсралтад Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх 10 шалгуур, Хүний нөөцийн ил тод байдлыг илтгэх 7 шалгуур үзүүлэлтийг тус тус баталсан.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар үйл ажиллагааны ил тод байдлын 9, хүний нөөцийн ил тод байдлын 5 үзүүлэлтээр биелэлтийг гаргуулж үнэлгээг өгөв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтийг **100** хувийн биелэлттэй дүгнэв.

#### ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

/2020 оны жилийн эцэс/

| №                          | Шалгуур үзүүлэлт                | Зөвлөлт   | Биелэлт, хувиар |          |          |          | Хугацаа болоогүй | Биелэлт хувиар |
|----------------------------|---------------------------------|-----------|-----------------|----------|----------|----------|------------------|----------------|
|                            |                                 |           | 100             | 70       | 30       | 0        |                  |                |
| 1                          | Үйл ажиллагааны нээлттэй байдал | 9         | 9               | 0        | 0        | 0        | 0                | 100            |
| 2                          | Хүний нөөцийн ил тод байдал     | 5         | 5               | 0        | 0        | 0        | 0                | 100            |
| <b>Хэрэгжилтийн дундаж</b> |                                 | <b>14</b> | <b>14</b>       | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b>         | <b>100</b>     |

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

#### 3.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.10-т зааснаар шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 04 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлдэг.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны шилэн дансны мэдээлэл, хэрэгжилтэд хяналт тавих болон мэдээллийг олон нийтэд хүргэх журмыг боловсруулан удирдлагаас санал авч Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/78 дугаар тушаалаар батлуулан, яамны сайтад байршуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 7 хоног тутам сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтад хяналт тавьж ажилласнаар 100 хувь мэдээллийг байршуулж хэвшүүлээ. Мөн сайдын эрхлэх асуудлын харьяанд байсан боловч татан буугдсан “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор” ХХК, “Эрдэнэс шивээ энерги” ХХК-ийг нэгдсэн сангаас хасуулахаар



Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 03/840 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хандаж шийдвэрлүүлсэн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар хяналт тавьж 4 байгууллагад Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03/2062-03/2065 дугаар албан бичгүүдээр зөвлөмжийг хүргүүлэн ажиллав.

Сангийн яамнаас дүгнэдэг төсвийн ерөнхийлөн захирагч нарын шилэн дансанд мэдээлэл байршуулалт, ил тод байдлын үзүүлэлтээр **90.2** хувиар дүгнэгдсэн байна.

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн багцад хамаарах хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээг тайланд орууллаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын хөрөнгөөр 2020 оны жилийн эцсийн байдлаар 32.53 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төрлийн худалдан авалтад 31.39 тэрбум төгрөг зарцуулахаар худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд **90,0** хувиар үнэлэгдэв. Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

Геологи хайгуул, судалгааны ажлын Үүрэг нуур-50, Цээл-50, Номингийн говь-50, Эрэл үнэлгээ-2 төслүүд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг 2020 оны төсвийн тодотголоор төсөвт өөрчлөлт орсонтой холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/219 дүгээр тушаалаар тендерийг зогсоосон тул үнэлэх боломжгүй байлаа.

Ашигт малтмал, газрын тосны газрын УИТ-85М багажны оношилгоо, засвар, үйлчилгээ худалдан авах ажиллагаа 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн төсвийн тодотголоор урсгал засварын зардлыг хассан шалтгаанаар тендерийг хойшлуулсан байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар 7, харьцуулалтын аргаар 2, шууд худалдан авалтаар 2 ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, 9 гэрээ байгуулж, 3 шууд худалдан авалт хийсэн байна. Бүх тендерийг хүчинтэй байх хугацаанд нь үнэлсэн байна.

Худалдан авах ажиллагааны явцад ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

Худалдан авах ажиллагааны талаар Сангийн яаманд 3 удаагийн гомдол гарснаас 2 гомдлыг Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрийн дагуу дахин үнэлгээг хийж шийдвэрлэсэн ба 1 гомдлыг Сангийн яамны 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 6-1/3913 дугаар албан бичгээр ирүүлсэн шийдвэрийн дагуу дахин үнэлгээг хийхээр үнэлгээний хороог өөрчлөн байгуулсан боловч 2020 оны төсвийн тодотголоор төсөвт өөрчлөлт орсон тул Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020

оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/219 дүгээр тушаалаар уг тендерийг зогсоосон байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээлж, худалдан авах ажиллагааны цахим системийг 2020 онд хийгдсэн бүх худалдан авалтад ашигласан байна.

АМГТГ-ын 2020 оны худалдан авах ажиллагааны биелэлт **90.0** хувиар үнэлэгдлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагааны тайлан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны тайланг үнэлэхэд “зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа” буюу **90.0** хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

### **3.3. БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ**

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.9-д заасны дагуу уг үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газраас гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 18.1.7.төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасан бөгөөд 2020 онд Авлигатай тэмцэх газраас шударга байдлын түвшний үнэлгээ хийгдээгүй гэсэн хариу ирүүлсэн.

### **3.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 дугаар тушаалаар сайдын 2021 оны төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Уг төлөвлөгөөнд яамны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх Хэрэглэгчийн үнэлгээний төсөв батлагдсан бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд хэрэглэгчийн үнэлгээний ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулсан.

Үнэлгээний хороо холбогдох хуулийн дагуу тендерийн баримт бичиг боловсруулах, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах ажлууд хийж гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээг хийж гүйцэтгэхээр 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр “Эс Ай Си Эй” ХХК шалгарч, хуулийн дагуу гэрээ байгуулан судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Ковид-19 цар тахлын улмаас судалгааны ажлын явц тодорхой хугацаагаар хойшлохоор болоод байна.

Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар батлагдсан, “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авах нарийвчилсан удирдамж, ажлын даалгавар,



## УУХҮЯ-ны 2020 оны жилийн эцсийн тайлан

түүвэр судалгаа авах асуулгыг боловсруулан гүйцэтгэгч компанид хүргүүлээд байна. Хэрэглэгчийн үнэлгээний тайланг гүйцэтгэгч компани гэрээний хугацаанд хийж дууссаны дараа хүргүүлэн ажиллах болно.

### 3.5 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, аймгуудын Засаг дарга нартай 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэв.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **71.4** хувьтай байна.

#### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

/2020 оны жилийн эцэс/

| №                     | Аймгийн нэр | Засаг даргын нэр | Гэрээний дугаар | Заалтын тоо | Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, хувиар |            |           |           |           |           |            | Биелэлтийн хувь |
|-----------------------|-------------|------------------|-----------------|-------------|---|------------|-----------|-----------|-----------|-----------|------------|-----------------|
|                       |             |                  |                 |             | 100                                     | 90         | 70        | 50        | 30        | 0         | -          |                 |
| 1                     | Архангай    | Д.Золжаргал      | 1               | 21          | 2                                       | 2          | 3         | 0         | 0         | 0         | 14         | 84.2            |
| 2                     | Баян-Өлгий  | Д.Бауыржан       | 2               | 24          | 1                                       | 6          | 5         | 3         | 1         | 2         | 6          | 65.0            |
| 3                     | Баянхонгор  | Д.Мөнхсайхан     | 3               | 26          | 0                                       | 6          | 3         | 7         | 3         | 1         | 6          | 59.5            |
| 4                     | Булган      | Б.Ариун-Эрдэнэ   | 4               | 24          | 2                                       | 3          | 4         | 1         | 0         | 1         | 13         | 72.7            |
| 5                     | Говь-Алтай  | О.Амгаланбаатар  | 5               | 23          | 0                                       | 4          | 2         | 7         | 0         | 0         | 10         | 65.3            |
| 6                     | Говьсүмбэр  | Г.Батзам         | 6               | 25          | 0                                       | 3          | 10        | 1         | 4         | 0         | 7          | 63.3            |
| 7                     | Дархан-Уул  | Б.Азжаргал       | 7               | 25          | 2                                       | 13         | 2         | 1         | 1         | 0         | 6          | 83.6            |
| 8                     | Дорноговь   | О.Батжаргал      | 8               | 26          | 1                                       | 11         | 4         | 3         | 0         | 2         | 5          | 72.3            |
| 9                     | Дорнод      | М.Бадамсүрэн     | 9               | 24          | 1                                       | 8          | 5         | 5         | 0         | 0         | 5          | 74.7            |
| 10                    | Дундговь    | Ц.Мөнхбат        | 10              | 23          | 2                                       | 8          | 7         | 0         | 0         | 1         | 5          | 78.3            |
| 11                    | Завхан      | Д.Түвшинжаргал   | 11              | 24          | 1                                       | 8          | 4         | 3         | 2         | 1         | 5          | 68.9            |
| 12                    | Орхон       | С.Батжаргал      | 12              | 26          | 1                                       | 10         | 8         | 3         | 0         | 0         | 4          | 77.7            |
| 13                    | Өвөрхангай  | А.Ишдорж         | 13              | 23          | 1                                       | 7          | 5         | 1         | 0         | 3         | 6          | 66.4            |
| 14                    | Өмнөговь    | Р.Сэддорж        | 14              | 25          | 2                                       | 6          | 5         | 4         | 1         | 1         | 6          | 69.4            |
| 15                    | Сүхбаатар   | М.Идэрбат        | 15              | 24          | 1                                       | 5          | 4         | 1         | 1         | 1         | 11         | 70.0            |
| 16                    | Сэлэнгэ     | Ш.Оргил          | 16              | 24          | 0                                       | 8          | 2         | 4         | 2         | 0         | 8          | 70.0            |
| 17                    | Төв         | Д.Мөнхбаатар     | 17              | 25          | 0                                       | 15         | 4         | 4         | 0         | 0         | 2          | 79.5            |
| 18                    | Увс         | Ч.Чимэд          | 18              | 24          | 1                                       | 11         | 4         | 2         | 2         | 0         | 4          | 76.5            |
| 19                    | Ховд        | Б.Дүгэржав       | 19              | 23          | 1                                       | 6          | 5         | 4         | 2         | 1         | 4          | 65.7            |
| 20                    | Хөвсгөл     | Л.Ганболд        | 20              | 23          | 0                                       | 4          | 4         | 1         | 2         | 1         | 11         | 62.5            |
| 21                    | Хэнтий      | Ц.Идэрбат        | 21              | 24          | 3                                       | 7          | 1         | 3         | 2         | 0         | 8          | 75.6            |
| <b>Үнэлгээний дүн</b> |             |                  |                 | <b>506</b>  | <b>22</b>                               | <b>151</b> | <b>91</b> | <b>58</b> | <b>23</b> | <b>15</b> | <b>146</b> | <b>71.4</b>     |

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.



#### 4. БУСАД АСУУДАЛ

##### 4.1 ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Гадаад хамтын ажиллагааны төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газар, Судалгаа хөрөнгө оруулалтын газар болон Ашигт малтмал, газрын тосны газраас тайлагнасан 4 төслийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, төслүүдийн үнэлгээ, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төлөвлөсөн ажлын биелэлт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгааны тайлан, мэдээ, гэрээний мэдээллийг нэгтгэсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 4 гадаадын зээл, тусламжийн төсөл 2020 онд хэрэгжсэн бөгөөд эдгээр төслүүд буцалтгүй тусламжаар санамж бичиг болон гэрээний хүрээнд тухайн улсын санхүүжилтээр хэрэгжиж байна.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн төслийн хэрэгжилт 2020 оны жилийн эцсийн байдлаар удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувийн хэрэгжилттэй 2 төсөл, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 70 хувийн хэрэгжилттэй 2 төсөл байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Европын сэргээн босголтын банк, Азийн хөгжлийн банк, Канад улсын Засгийн газар, Австрали улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 4 төсөл хэрэгжиж байна. Төслийн хэрэгжилт 2020 оны жилийн эцсийн байдлаар **79.2** хувьтай үнэлэгдэв.

##### ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ /2020 оны жилийн эцсийн байдлаар/

| №               | Төслийн нэр  | Зорилтын тоо | Үнэлгээ (хувь) |          |          |          |          | Хэрэгжилт (хувь) |
|-----------------|--|--------------|----------------|----------|----------|----------|----------|------------------|
|                 |  |              | 100            | 70       | 40       | 0        | /-       |                  |
| 1               | Монгол Улс – Олборлох салбарын ил тод байдал–Үндэсний Геологи, Эрдэс Баялгийн Мэдээллийн Сан төсөл (ЕСБХБанк)  | 4            | 0              | 4        | 0        | 0        | 0        | 70               |
| 2               | Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT (Канад улсын ЗГ) | 3            | 0              | 3        | 0        | 0        | 0        | 70               |
| 3               | Олборлох салбарын засаглалыг сайжруулах төсөл (Азийн хөгжлийн банк)  | 3            | 2              | 1        | 0        | 0        | 0        | 90               |
| 4               | Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/, АМЕР-2 (Австрали улсын ЗГ)  | 3            | 2              | 1        | 0        | 0        | 0        | 90               |
| <b>Нийт дүн</b> |  | <b>13</b>    | <b>4</b>       | <b>9</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>79.2%</b>     |



Сангийн яамнаас албан бичгээр ирүүлсэн хавсралт 7 хүснэгтийн дагуу гадаад зээл, тусламжийн төслүүдийн үнэлгээ, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгааны талаарх мэдээллийг Мерит, АМЭП, Олборлох салбарын засаглалыг сайжруулах төсөл хэрэгжүүлэгчид бүрэн тайлагнасангүй.

Гадаадын зээл, тусламжийн төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/455 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажиллав.

#### **4.2 УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Засгийн газрын 2018 оны “Хөтөлбөр батлах тухай” 140 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Хөтөлбөр тодотгон батлах тухай” 290 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн шалгуур үзүүлэлтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан төслүүдийг хяналтад авч, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэн, дүгнэлт, зөвлөмж гаргав.

“Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар шилжин хэрэгжих төсөл 9, шинээр хэрэгжүүлэх төсөл 4, нийтдээ 13 төсөл байгаагаас уул уурхайн 4, хүнд үйлдвэрийн 6, газрын тосны 3 төсөл байна. Хөтөлбөрт тусгагдсан 13 төслийн 2020 оны жилийн эцсийн биелэлт **70.0 хувьтай**, үүнээс 3 төсөл “үр дүн гарч байгаа” 90 хувь, 8 төсөл “гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа” 70 хувь, 1 төсөл “тодорхой хэмжээнд ажил эхэлсэн” 50 хувь, 1 төсөл “боловсруулалтын шатанд байгаа” 30 хувийн биелэлттэй байна.

#### **МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭЛ (2020 оны жилийн эцэс)**

| №               | Төслийн нэр                | Төслийн тоо | Хэрэгжилтийн хувь |          |          |          |          | Үнэлгээ хувь | Уул уурхай | Хүнд үйлдвэр | Газрын тос |
|-----------------|----------------------------|-------------|-------------------|----------|----------|----------|----------|--------------|------------|--------------|------------|
|                 |                            |             | 90                | 70       | 50       | 30       | 0        |              |            |              |            |
| 1               | Шилжин хэрэгжих төслүүд    | 9           | 2                 | 7        | 0        | 0        | 0        | 74.4         | 4          | 3            | 2          |
| 2               | Шинээр хэрэгжүүлэх төслүүд | 4           | 1                 | 1        | 1        | 1        | 0        | 60.0         | 0          | 3            | 1          |
| <b>Нийт дүн</b> |                            | <b>13</b>   | <b>3</b>          | <b>8</b> | <b>1</b> | <b>1</b> | <b>0</b> | <b>70.0</b>  | <b>4</b>   | <b>6</b>     | <b>3</b>   |

Үнэлгээний тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/189 дугаар албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлж ажиллав.

## V. ДҮГНЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр дүн, салбарын үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах зэрэг асуудалд өргөн хүрээтэй хандаж, 2020 онд төлөвлөсөн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.

Манай улсад коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал гарсантай холбоотой Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын болон хатуу хөл хорионы зэрэгт шилжүүлсэн үед Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь өндөр зохион байгуулалттайгаар улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засагт үүссэн хүндрэл бэрхшээл болон цар тахлыг даван туулах, эдийн засгийг сэргээхэд онцгой хувь нэмэр оруулан ажилласан.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн биелэлт **84.7%**-тай, ерөнхий үнэлгээг **4.24** оноогоор дүгнэв.

## 6. ЗӨВЛӨМЖ

Бодлогын зорилтын хэрэгжилтийн талаар:

- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар нийт 17 зорилтын 72 арга хэмжээ, үүнээс 42 арга хэмжээг яам толгойлон, 30 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагад ханддаггүй зэрэг асуудал гарч байгааг анхаарч толгойлон хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах талаар яамны бодлогын газруудын зүгээс санаачлага гарган ажиллах;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргахдаа тухайн зорилтын хүрээнд хийгдсэн ажил, явцын мэдээлэл, гарсан шийдвэр, хүрсэн үр дүнгийн түвшинг товч тодорхой, гүйцэд тайлагнах, тухайн тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн арга хэмжээний биелэлт гаргаж ирүүлэх тал дээр нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд онцгой анхаарч ажиллах;
- Хууль тогтоомжийн биелэлтэд тухайн шийдвэр заалтыг хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээний талаар товч, тодорхой биелэлт гаргах, холбогдох тушаал шийдвэрийн огноо дугаар, агуулгыг дурдаж байх, бүрэн хэрэгжсэн гэж үзвэл уг шийдвэр заалтыг хяналтаас хасуулах саналын хамт гаргаж ирүүлж хэвших. Төрийн захиргааны удирдлагын газрын зүгээс тогтоол шийдвэр хяналтанд авагдсан тухай бүр тэдгээрийг бүх албан хаагчдад хүргүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах нь зүйтэй байна.



**Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн талаар:**

- Яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил үйлчилгээний шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ, хугацаа, чанар/-ийг оновчтой төлөвлөж, уг ажил үйлчилгээг эзэнжүүлэх, биелэлтийг шалгуур үзүүлэлттэй нь уялдуулан тайлагнах;
- Ажил үйлчилгээний биелэлтийг бичмэл хэлбэрээс гадна зураг, дүрс, график ашиглан тайлагнахад анхаарах шаардлагатай.

**Байгууллагын нээлттэй байдлын талаар:**

- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ерөнхий агуулгатай гаргаж байгаа тул цаашид шалгуур үзүүлэлт /Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд/-ийг хангах хүрээнд тухайн тайлант жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тоо баримттай, огноо дугаартай тодорхой биелэлт гаргаж байх тал дээр анхаарах шаардлагатай.

**Үйл ажиллагааны үр дагаварын талаар:**

- Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлт тусгагдсан суурь болон зорилтот түвшний тоон үзүүлэлтийг бодлогын баримт бичгүүдэд тусгасан тоон болон чанарын үзүүлэлттэй уялдуулж төлөвлөх, тухайн тайлант жилд хүрсэн түвшинг үнэн зөв гаргаж байхад бодлогын газрууд анхаарч ажиллах.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН  
(2020 оны жилийн эцэс)**

|  | Үзүүлэлт  | Хувь        | Жин        | Оноо |
|--|---|-------------|------------|------|
| 1  | 2   | 3           | 4          | 5    |
| Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ | 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт   | 90.3        | 0.6        | 4.24 |
|  | 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт   | 50.3        |            |      |
|  | 3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт                        | 73.57       |            |      |
|  | 4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ   | 74.83       |            |      |
| Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ | 1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт                             | 98.4        | 0.2        |      |
|  | 2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт | 100         |            |      |
| Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ        | 1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ  | 100         | 0.2        |      |
|  | 2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ /СЯ/  | 90.2        |            |      |
|  | 3. Шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ/  | /-/         |            |      |
|  | 4. Хэрэглэгчийн үнэлгээ   | /-/         |            |      |
| <b>Ерөнхий үнэлгээ:</b>                      |   | <b>84.7</b> | <b>1.0</b> |      |

VI. ХАВСРАЛТ

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны биелэлт;
- Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг биелэлт.

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Ц.Одхүү

Нэгтгэн боловсруулсан:

Ахлах шинжээч

Х.Цэнд-Аюуш

ХШҮ хийж, тайлан

боловсруулсан:

Шинжээч

Н.Цогтбаяр

Ахлах мэргэжилтэн

Д.Батнайрамдал

Мэргэжилтэн

Ж.Энхсайхан

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2021.03.29

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦ БОЛОН ХАРЪЯА  
БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр

2020 оны жилийн эцсийн байдлаар

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын хөрөнгөөр 2020 оны жилийн эцсийн байдлаар 32.53 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төрлийн худалдан авалтад 31.39 тэрбум төгрөг зарцуулахаар худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тсгтоолоор баталсан журмын дагуу Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд **90,0** оноогоор үнэлэгдэв.

1.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

1.3 Геологи хайгуул, судалгааны ажлын Үүрэг нуур-50, Цээл-50, Номингийн говь-50, Эрэл үнэлгээ-2 төслүүд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажил 2020 оны төсвийн тодотголоор төсөвт өөрчлөлт орсон тул УУХҮ-ийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/219 дүгээр тушаалаар тендерийг зогсоосон тул үнэлэх боломжгүй байлаа.

1.4 Ашигт малтмал, газрын тосны газрын УИТ-85М багажны оношилгоо, засвар, үйлчилгээ худалдан авах ажиллагаа 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн төсвийн тодотголоор урсгал засварын зардлыг хассан шалтгаанаар тендерийг хойшлуулсан байна.

1.5 Нээлттэй тендер шалгаруулалтаар 7, харьцуулалтын аргаар 2, шууд худалдан авалтаар 2 ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, 9 гэрээ байгуулж, 3 шууд худалдан авалт хийсэн байна. Бүх тендерийг хүчинтэй байх хугацаанд нь үнэлсэн байна.

1.6 Худалдан авах ажиллагааны явцад ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

1.7 Худалдан авах ажиллагааны талаар Сангийн яаманд 3 удаагийн гомдол гарснаас 2 гомдлыг Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрийн дагуу дахин үнэлгээг хийж, шийдвэрлэсэн. Үлдсэн 1 гомдлын хуеьд Сангийн яамны 2020 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 6-1/3913 тоот албан бичгээр ирүүлсэн шийдвэрийн дагуу дахин үнэлгээг хийхээр үнэлгээний хороог өөрчлөн байгуулсан боловч 2020 оны төсвийн тодотголоор төсөвт өөрчлөлт орсон тул Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/219 дүгээр тушаалаар уг тендерийг зогсоосон байна.

1.8 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээлж хэвшсэн байна.

1.9 Тайланд худалдан авсан барааны мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэрийг бүрэн тусгасан. Харин гэрээний хэрэгжилтийн талаар тайлбар ирүүлээгүй байна.

**Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим систем ашигласан талаар**

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системийг 2020 онд бүх худалдан авалтад ашигласан байна.

**Гурав. Харъяа төсөвт байгууллагын худалдан авах ажиллагааны талаар**

3.1 Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны худалдан авах ажиллагааны биелэлт **90,0** хувиар үнэлэгдсэн.



3.2 Шинээр байгуулагдсан Үндэсний геологийн албаны худалдан авалтыг яамны хэмжээнд багцаар тендер зарлаж зохион байгуулсан байна.

### Дөрөв. Дүгнэлт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагааны тайлан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасан шаардлагыг бүрэн хангасан байна. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу худалдан авах ажиллагааны тайланг үнэлэхэд “зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа” буюу **90,0** хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

### Тав. Санал зөвлөмж

1. Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний талаар тайлбар, үндэслэлийг тоо баримттайгаар тайлагнах;
2. Гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, гэрээнд заасан хугацаанд бараа, ажил үйлчилгээг хүлээн авах ажлыг зохион байгуулах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох;
3. Ажлын биелэлтийг гаргахдаа үнийн дүн болон хувиар илэрхийлэн, үнэлж болохуйцаар тайлагнаж хэвших;
4. Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулж, хийгдэх боломжгүй тухайлбал геологи хайгуул судлагааны ажлыг төлөвлөлтийн шатанд үнэлгээ хийлгэж байх.

Тайлбар: Тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасан загвараар боловсруулав.

Хянасан: ХШУДАГ-ын дарга



Ц.Одхүү

Тайлан бичсэн:

ХШУДАГ-ын мэргэжилтэн



Х.Цэнд-Аюуш /2021.01.28/

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.

2021 оны 03 сарын 22

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж өгөх замаар яамны ил тод, нээлттэй, шуурхай зарчмыг хангаж, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, улмаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон яамны удирдлагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Хяналт-шинжилгээ, үнэлгээг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэс болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн Газрын 2009 оны 143 дүгээр тогтоолын хавсралтад Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх 10 шалгуур, Хүний нөөцийн ил тод байдлыг илтгэх 7 шалгуур үзүүлэлтийг баталсан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар үйл ажиллагааны ил тод байдлын 9, хүний нөөцийн ил тод байдлын 5 үзүүлэлтээр биелэлтийг гаргуулж үнэлгээг өгөв.

**ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ**

/Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам/

2020 оны жилийн эцэс

| №                                  | Шалгуур үзүүлэлт   | Хэрэгжилт   | Хувь |
|------------------------------------|--|---|------|
| Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал |  |   |      |
| 1.                                 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан цаг тухай бүрт нь тогтмол шинэчилж, баяжуулалтыг хөтлөн явуулж байна. | 100  |

|    |   |  |     |
|----|---|--|-----|
| 2. | <p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> | <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> сайтын толгой хэсэгт бичиг хэргийн ажилтны харилцах утас, цахим хаягийг, БИДНИЙ ТУХАЙ цэсийн “Холбоо барих” дэд цэс-д байгууллагын бүх газар, хэлтсийн нэр, чиг үүрэг, албан хаагчдын албан тушаал, овог, нэр, утасны дугаарыг <a href="http://www.mmhi.gov.mn/public/page/pageid/7">http://www.mmhi.gov.mn/public/page/pageid/7</a> цахим хуудсанд тус тус байршуулсан.</p> <p>Өргөдөл гомдол хариуцсан албан хаагч нь цахимаар болон бичгээр ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдлыг тухай бүрт нь хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд иргэд, байгууллагаас захидал, өргөдөл хүлээн авах ажилтны нэр, холбогдох утасны дугаарыг яамны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> сайтын төгсгөл хэсэгт ил харагдахаар байршуулсан.</p> <p>Иргэд, аж ахуйн нэгжээс УУХҮЯ, АМГТГ-т ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй тайланг улирал бүр ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.</p> | 100 |
| 3. | <p>Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>   | <p>Яамны цахим сайтын ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ цэс-д Газрын тос, тэсэлгээ, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд авх тусгай зөвшөөрлийн журам, бүрдүүлэх материалын жагсаалт, хариуцсан, мэдээлэл өгөх ажилтны нэр, утасны дугаар болон тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг ил тод мэдээлсэн. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг тухай бүр шинэчлэж байна. <a href="http://mmhi.gov.mn/public/page/pageid/7">http://mmhi.gov.mn/public/page/pageid/7</a></p>   | 100 |
| 4. | <p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>   | <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> цахим хуудасны ХУУЛЬ, ТОГТООМЖ цэс-д хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журам, зааврыг тогтмол шинэчлэн байршуулж байна.</p>   | 100 |
| 5. | <p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг</p>          | <p>Яамны цахим сайтын ХЭЛЭЛЦҮҮЛЭГ цэсэд 1 хууль, 8 журмын төслийг байршуулж тухайн хэлэлцүүлгийг хариуцах ажилтантай холбогдох мэдээллийг байршуулсан. Цахим хуудсаар хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан. Тус яамнаас боловсруулсан дараах хууль тогтоомжийн төсөлд иргэд, олон нийт, бусад байгууллагаас санал авахаар цахим хуудасны хэлэлцүүлэг хэсэгт байршуулсан.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмын шинэчилсэн найруулгын төсөл;</li> <li>2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм, шинжээчийн хөлс тооцох аргачлал;</li> <li>3. Тэсэлгээний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам;</li> <li>4. Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох журам;</li> </ol>  | 100 |



|    |   |   |     |
|----|---|---|-----|
|    | <p>авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;</p>  | <p>5. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль;<br/>         6. Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн төсөл;<br/>         7. Аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох журам;<br/>         8. Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн төсөл;<br/>         9. Газрын тос уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам.</p>   |     |
| 6. | <p>Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p>  | <p>Яамнаас салбарын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж буй гол тавцан нь яамны цахим хуудас гэж үзэж цаг үеийн асуудлаар яамны удирдлага болон газар хэлтсийн дарга нарын өгсөн ярилцлага, видео бичлэгийг тухайн бүр байршуулж байна.</p> <p>Яамны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс иргэд, олон нийтэд хандан “Ил тод, хариуцлагатай уул уурхай” сэдэвт Хэлэлтийн хурлыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч цар тахлын нөхцөл байдлын үед эрсдэлтэй гэж үзэн хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна. Коронавирусын хаг двараас сэргийлэхийн тулд яам болон харьяа агентлагуудын үйл ажиллагааг аль болох цахим хэлбэрт шилжүүлэн олон нийт, хэвлэл мэдээлэлтэй цахимаар холбогдон мэдээлэл өгөх, ажилчдын дийлэнх хувийг гэрээсээ ажиллах боломж нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн үүнээс гадна хэдий цар тахлын нөхцөл байдалд байгаа ч цахим боломжийг ашиглан салбарын эмэгтэй ажилчдын оролцоог хангах, тэдний жөндөрийн болон хариуцлагатай уул уурхайн ойлголт, мэдлэгийг тэлэх, идэвхжүүлэх, урам зориг өгөх, чиглүүлэх зорилгоор “ЭРДЭС БАЯЛАГ-ЭМЭГТЭЙЧҮҮД ҮНДЭСНИЙ III ЧУУЛГАН”-ыг цахимаар зохион байгуулж салбарын манлайлагч эмэгтэйчүүд туршлага, амжилт ололтоо чуулганд оролцогч 300 гаруй эмэгтэйчүүдтэй хуваалцсан юм. Түүнчлэн УУХҮЯ-ны үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой 210 мэдээ, мэдээллийг бэлтгэж яамны цахим хуудас болон социал хуудсаар нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг гээээт болон гэрээт бус хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан. Мөн гэрээт болон гэрээт бус телевизүүдээр яамны үйл ажиллагааг сурталчилсан нэтрүүлэг, штерк, ярилцлага цацагдсан болно.</p> | 100 |
| 7  | <p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1/1.Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн</p> | <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017.01.03-ны өдрийн А-01 дүгээр тушаалар батлагдсан “Хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэнд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам”-ын дагуу металлург, металл боловсруулалт, машин үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүдэд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийн сургалтын баазыг, нефть, химийн салбарын мэргэжилтнүүдэд тус сургуулийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн сургалтын баазыг тус тус түшиглэн 2017 оноос хойш жил бүр сургалт зохион байгуулж, салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг УУХҮСайдын тушаалаар, мөн Уул уурхайн сайдын 2015.03.12-ны 53 дугаар тушаалаар батлагдсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох” журмын дагуу Монгол Улсын газрын тосны салбарын инженерүүдэд мэргэжлийн зэргийг “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, газрын тосны сургуульд түшиглэсэн Сургалт-мэдээллийн сектор” төвөөр дамжуулан 2016 оноос хойш сургалт зохион байгуулж, салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тус тус олгож байна.</p>   | 100 |

|   |   |   |            |
|---|---|---|------------|
|   | санхүүжүүлж болно./дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | “Хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэнд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам” болон “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам”-ын дагуу хүнд үйлдвэрийн салбарын болон газрын тосны салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох Зөвлөл ажиллаж, мэргэжлийн зэрэг олгох шалгаруулалт зохион байгуулах, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, бууруулах, цуцлах, хүчингүй болгох талаар шийдвэр гаргах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, зэрэгтэй инженерийн талаар гарган гомдлыг хүлээн авч, хянаж, Зөвлөлд танилцуулах, Зөвлөлөөс гарсан аливаа шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг гүйцэтгэдэг.<br>Сургалтай холбоотой зарын мэдээллийг тухай бүр яамны “Мэдээ, мэдээлэл” дэд цэсэд тогтмол байршуулж ажиллаж байна. |            |
| 8.  | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;                     | Яамны цахим сайтын ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ цэсэд Газрын тос, тэсэлгээ, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд авах тусгай зөвшөөрлийн журам, бүрдүүлэх материалын жагсаалт, хариуцсан, мэдээлэл өгөх ажилтны нэр, утасны дугаар болон тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг ил тод мэдээлсэн болно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг тухай бүр шинэчлэж байна. <a href="http://mmhi.gov.mn/public/page/pageid/7">http://mmhi.gov.mn/public/page/pageid/7</a>  | 100        |
| 9.  | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;   | Эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй гадаадын зээл, буцалтгүй тусламж, хамтарсан төслүүдийн 2020 оны хэрэгжилтэд ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэлт зөвлөмжийг яамны цахим хуудасны ИЛ ТОД БАЙДАЛ цэсний ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ дэд цэсэд тогтмол байршуулж ажиллаж байна.   | 100        |
| <b>Хэсгийн дундаж хувь:</b>               |   |   | <b>100</b> |
| <b>Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;</b> |   |   |            |



|    |  |   |     |
|----|--|---|-----|
| 1. | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Яамны болон харьяа агентлагийн сул ажлын байранд Төрийн албаны тухай хуульд заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журам болон бусад холбогдох журмын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд, тус тус байршуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаж байна. 2020 оны байдлаар сул ажлын байр гараагүй болно.   | 100 |
| 2. | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;  | Яамны албан хаагч бүрт Ёс зүйн дүрмийг танилцуулан хувийн хэрэгт нь ёс зүйн дүрэмтэй танилцсан баталгааг хавсаргасан. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэлд Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.<br>Яамны дотоод сүлжээний олон нийтийн хэлэлцүүлэг хэсэгт Төрийн албаны зөвлөлөөс санаачлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн дэмжлэгтэйгээр улсын хэмжээнд анх удаа зохион байгуулсан "Төрийн байгууллагуудын "Төрийн албаны шинэтгэл-ёс зүйн хандлага" сэдэвт төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөл"-ийн нэгдсэн зөвлөгөөний илтгэлүүд байршуулж танилцуулсан. Мөн Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн ажиллах нийтлэг журмын төслийг байршуулж санал авсан. 2020 оны жилийн тайлант хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал газрын тосны газар, Үндэсний геологийн албаны Ёс зүйн зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл ирээгүй бөгөөд Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбоотой ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх асуудал 2020 оны байдлаар хэлэлцэгдээгүй болно. | 100 |
| 3. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;                                 | Төсвийн шууд захирагчийн болон нэгжийн менежер, төрийн жинхэнэ албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулах, үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдон гарсан Төрийн албаны зөвлөлийн журмыг яамны цахим хуудсанд байршуулан мөрдөж ажиллаж байна.   | 100 |
| 4. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа  | Яамны цахим хуудсанд "Хүний нөөцийн ил тод байдал" цэсэд хүний нөөцтэй холбоотой хууль тогтоомжууд, Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Төрийн албаны зөвлөлийн салбарын зөвлөлийн төлөвлөгөө, тайлан, хуралдааны тойм болон бусад мэдээллийг тогтмол байршуулж дотоод сүлжээгээр яамны нийт албан хаагчдад мэдээллэж байна.  | 100 |

|                                  |  |   |            |
|----------------------------------|--|---|------------|
|                                  | ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;   |   |            |
| 5.                               | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх Үнэлгээний багийг Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан. Төрийн жинхэнэ албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн тайланг нэгжийн даргаар үнэлүүлж, үнэлгээний багийн гишүүд болон төсвийн шууд захирагчаар баталгаажуулан үр дүнгийн гэрээг үнэн зөв, шударга дүгнэж ажилласан. | 100        |
| <b>Хэсгийн дундаж хувь:</b>      |  |   | <b>100</b> |
| <b>Хэрэгжилтийн дундаж хувь:</b> |  |   | <b>100</b> |

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтүүдийг **100** хувийн биелэлттэй дүгнэв.

#### ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

/2020 оны эцэс/

| №                           | Шалгуур үзүүлэлт                | Заалт     | Биелэлт, %/ |          |          |          | Хугацаа болоогүй | Биелэлт %/ |
|-----------------------------|---------------------------------|-----------|-------------|----------|----------|----------|------------------|------------|
|                             |                                 |           | 100         | 70       | 30       | 0        |                  |            |
| 1                           | Үйл ажиллагааны нээлттэй байдал | 9         | 9           | -        | -        | -        | -                | 100        |
| 2                           | Хүний нөөцийн ил тод байдал     | 5         | 5           | -        | -        | -        | -                | 100        |
| <b>Хэрэгжилтийн дундаж:</b> |                                 | <b>14</b> | <b>14</b>   | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b>         | <b>100</b> |

#### **Дөрөв. Дүгнэлт**

**Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:**

- Байгууллагын стратеги зорилт, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт, байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд шаардлагатай мэдээлэл, олгож буй тусгай зөвшөөрөл, төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллүүд, түүнтэй холбогдолтой дүрэм журмыг цахим хуудсанд байршуулж хэвшсэн тул 100 оноогоор үнэлэв.
- Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгийн төслийг цахим хуудсаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлж сонирхогч талуудын оролцоог хангах, санал сэтгэгдлийг авч ажиллаж байна.

## Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:

- “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд хүний нөөцтэй холбоотой хууль тогтоомжууд, Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Төрийн албаны зөвлөлийн салбарын зөвлөлийн төлөвлөгөө, тайлан, хуралдааны тойм болон бусад мэдээллийг тогтмол байршуулж дотоод сүлжээгээр яамны нийт албан хаагчдад мэдээллэх, “Төрийн захиргааны бслон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөх, Яамны болон харъяа агентлагийн сул ажлын байранд Төрийн албаны тухай хуульд заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журмуудыг мөрдлөгө болгон хэвшсэн байна.


### **Тав. Санал, зөвлөмж**

- Яамны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг тогтмол шинэчилж, яамнаас зохион байгуулж хийсэн томоохон ажлыг иргэд олон нийтэд мэдээлэх
- Биелэлтийг тоо баримт, огноотой нотлох баримтын шаардлага хангуулан тайлагнах.

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга  Ц.Одхүү

Үнэлгээ хийж тайлан бол овсруулсан:

Ахлах шинжээч  Х.Цэнд-Аюуш /2021.03.22/



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2020 оны жилийн эцэс/**

2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолооср баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолыг тус тус удирдлага болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, мегалл, шатах ашигт малтмалын үйлдвэрлэлийн 9 ангиллын 19 үзүүлэлтийг Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар батлагдсан. Эдгээрээс тайлант хугацаанд 4 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн буюу давж биелсэн бол үлдсэн 12 үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, буурсан гүйцэтгэлтэй байна.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ,  
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ  
/2020 оны жилийн эцэс/**

| № | Үзүүлэлт   | Суурь үзүүлэлт /2016/ | Эхний жил /2017 он/ |               | 2 дахь жил /2018 он/ |               | 3 дахь жил /2019 он/ |               | 4 дэх жил /2020 он/ |               |          |         |      |
|---|--|-----------------------|---------------------|---------------|----------------------|---------------|----------------------|---------------|---------------------|---------------|----------|---------|------|
|   |  |                       | Зорилтот түвшин     | Хүрсэн түвшин | Зорилтот түвшин      | Хүрсэн түвшин | Зорилтот түвшин      | Хүрсэн түвшин | Зорилтот түвшин     | Хүрсэн түвшин | Өөрчлөлт | Үнэлгээ |      |
|   |  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          | Хувь    | Оноо |
| 1 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)                     | 34.6                  | 37.0                | 37.4          | 38.4                 | 38.7          | 41.0                 | 43.50         | 41.0                | 41.06         | 0.06     | 100     | 5.0  |
| 2 | Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг зохиох төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх) | 86.0                  | 100.0               | 100.0         | 100.0                | 92.1          | 92.0                 | 94.00         | 100.0               | 92.11         | -7.89    | 92      | 4.6  |
| 3 | <b>Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ</b>  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          |         |      |
|   | Газрын тос (мянган баррель)  | 8,249.8               | 7,971.1             | 7,632.6       | 10,850.7             | 6,138.4       | 10,899.1             | 6,875.5       | 10,899.1            | 4,082.2       | 6,816.9  | 37.5    | 1.9  |
|   | Нүүрс (сая тонн)   | 35.4                  | 47.1                | 47.1          | 37.0                 | 50.0          | 41.1                 | 50.8          | 41.1                | 43.1          | 2.0      | 104.8   | 5.0  |
|   | Зэсийн баяжмал (мянган тонн)   | 1,445.1               | 1,310.0             | 1,317.1       | 1,500.0              | 1,310.8       | 1,820.0              | 1,262.4       | 1,920.0             | 1,275.7       | -644.3   | 66.4    | 3.3  |
|   | Төмрийн хүдэр (сая тонн)   | 4.9                   | 10.0                | 7.7           | 10.0                 | 6.2           | 10.0                 | 12.0          | 10.0                | 9.2           | -0.8     | 92.0    | 4.6  |
|   | Алт (тонн)   | 18.4                  | 19.8                | 19.8          | 20.0                 | 21.9          | 23.0                 | 16.3          | 23.0                | 23.6          | 0.6      | 102.5   | 5.0  |
| 4 | <b>Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ</b>  |                       |                     |               |                      |               |                      |               |                     |               |          |         |      |
|   | Газрын тос (мянган баррель)  | 8,015.9               | 7,100.0             | 7,514.2       | 10,100.0             | 6,339.0       | 10,100.0             | 6,546.6       | 10,100.0            | 4,070.5       | 6,029.5  | 40.3    | 2.0  |

|   |  |         |         |         |         |         |         |         |         |         |        |       |      |
|---|--|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|--------|-------|------|
|   | Нүүрс (сая тонн)                                       | 25.7    | 33.4    | 33.0    | 25.5    | 35.8    | 28.0    | 36.6    | 28.0    | 28.7    | 0.7    | 102.4 | 5.0  |
|   | Зэсийн баяжмал (мянган тонн)                           | 1,562.0 | 1,280.0 | 1,447.2 | 1,620.0 | 1,436.7 | 1,720.0 | 1,403.6 | 1,720.0 | 1,395.1 | -324.9 | 81.1  | 4.1  |
|   | Төмрийн хүдэр (сая тонн)                               | 6.1     | 6.2     | 6.3     | 10.0    | 7.4     | 10.0    | 12.0    | 10.0    | 8.2     | -1.8   | 82.0  | 4.1  |
|   | Алт (тонн)   | 19.2    | 15.0    | 14.6    | 15.0    | 3.4     | 15.0    | 9.1     | 15.0    | 30.5    | 15.5   | 203.3 | 5.0  |
| 5 | Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ (сая тонн) | 1.22    | 1.49    | 1.50    | 1.40    | 1.79    | 1.50    | 2.00    | 1.50    | 1.95    | 0.45   | 130.0 | 5.0  |
|   | Үүнээс: ОХУ-аас  | 1.16    | 1.44    | 1.46    | 1.30    | 1.79    | 1.30    | 1.90    | 1.30    | 1.81    | 0.51   | 139.3 | 5.0  |
|   | Бусад улсаас   | 0.06    | 0.05    | 0.04    | 0.10    | 0.08    | 0.20    | 0.18    | 0.20    | 0.13    | -0.07  | 66.5  | 3.3  |
| 6 | Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл (мян. тн)       |         |         |         |         |         |         |         |         |         |        |       |      |
|   | Дизель түлш  | 30.0    | 30.0    | 32.0    | 30.0    | 29.0    | 30.0    | 98.9    | 30.0    | 2.3     | -27.7  | 8.0   | 0.4  |
|   | Автобензин   | 15.0    | 15.0    | 20.0    | 15.0    | 3.5     | 30.0    | 8.8     | 30.0    | 0.0     | -30.0  | 0.0   | 0.0  |
|   | Мазут  | 5.0     | 5.0     | 10.0    | 5.0     | 3.5     | 10.0    | 0.4     | 10.0    | 1.2     | -8.8   | 12.0  | 0.6  |
| 7 | Ган бүтээгдэхүүн (мянган тонн)                         | 40.0    | 50.0    | 60.0    | 50.0    | 70.1    | 50.0    | 75.0    | 50.0    | 64.8    | 14.8   | 129.6 | 5.0  |
| 8 | Катодын зэс (мянган тонн)                              | 15.0    | 15.0    | 14.7    | 15.0    | 14.2    | 25.0    | 11.7    | 25.0    | 9.5     | -15.7  | 38.0  | 1.9  |
| 9 | Ангжруулсан төмөр (мянган тонн)                        | -/-     | -/-     | -/-     | -/-     | -/-     | 500.0   | 0.0     | 500.0   | 0       | -500   | 0.0   | 0.0  |
|   | УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ          |         |         |         |         |         |         |         |         |         |        | 74.83 | 3.74 |

Тайлангийн хугацаанд газрын тос, зэсийн баяжмал олборлолт, болон экспортын хэмжээ, ОХУ-аас бусад улсаас импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ, дотоодод үйлдвэрлэсэн дизель түлш, автобензин, мазутын үйлдвэрлэл, катодын зэс, ангижруулсан төмрийн үйлдвэрлэл тус тус буурсан дүнтэй байна.

Газрын тосны олборлолт 37.5%, экспорт 40.3%-ийн тус тус гүйцэтгэлтэй гарсан нь шинэ төрлийн коронавирус /Ковид 19/ цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хилийн боомтуудын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож, газрын тосны экспортын тээвэрлэлийн үйл ажиллагааг 2020.01.30-ны өдрөөс эхлэн бүрэн зогсоосон нь газрын тосны 2020 оны олборлолт, экспортын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн болно.

Засгийн газрын шийдвэрийн дагуу “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ын дагуу 2020.04.15-ны өдрөөс эхлэн Тамсаг XXI талбайгаас Баянхошуу хилийн боомтоор хоногт 24 автоцистернээр, 2020.06.16-ны өдрөөс эхлэн Тосон-Уул XIX талбайгаас Бичигтийн хилийн боомтоор хоногт 25 автоцистернээр газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тус тус сэргээн явуулж эхэлсэн. Өнөөгийн байдлаар Тосон-Уул XIX талбайгаас хоногт дунджаар 319 цооногоор 1235 тонн газрын тос олборлож, 39 автоцистернээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Бичигт боомтоор, Тамсаг-XXI талбайгаас хоногт дунджаар 306 цооногоор 1204 тонн газрын тос олборлож, 33 автоцистернээр Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Баянхошуу боомтоор, БХГ-97 талбайгаас 103 цооногоор дунджаар 1080 баррель буюу 151 тонн газрын тос олборлож, 7 хоногт 1 удаа 21 вагонцистернээр дунджаар 8350 баррель буюу 1150 тонн газрын тос олборлож, Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтоор БНХАУ-д тус тус экспортолж байна.

Мөн дээрх шалтгааны улмаас газрын тосны үйлдвэрлэлийн тухайд дизелийн түлшний үйлдвэрлэл 8.0%, автобензин 0.0%, мазутын үйлдвэрлэл 12%-иар биелсэн байна.

Дээрхтэй ижил нөхцөл байдал катодын зэсийн үйлдвэрлэл дээр мөн харагдаж байна. Тухайлбал 2020 онд нийт 9,5 мянган тонн катодын зэс үйлдвэрлэсэн нь зорилтот түвшингийн 38%-ийг хангасан байна. Одоогийн байдлаар “Эрдмин” ХХК жилд 5.0 мянган тонн, “Ачит ихт” ХХК жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтайгаар ажиллаж байгаа ба нийлбэр дүнгээр жилд 11.0-15.0 мянган тонн (2015 онд 14.9 мян.тн, 2016 онд 15.1 мян.тн, 2017 онд 14.7 мян.тн, 2018 онд 14.2 мян.тн, 2019 онд 11.7 мян.тн, 2020 онд 9.5 мян.тн) катодын зэс үйлдвэрлэж байна.

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК-ийн “Уул уурхай, металлургийн цогцолбор” байгуулах концепци төлөвлөгөө”-г “шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх”, “барих-шилжүүлэх” нөхцөлтэйгээр “Кью Эс Си” ХХК болон Эдийн Засгийн Хөгжлийн Яам /хуучнаар/-тай нь 2014 оны 04 дүгээр сард Концессын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан байна.

Дээрх төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 1-р шатны ажлууд болох төмрийн хүдрийн ордуудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэд бүтцийн хамт байгуулах ажлуудыг хэрэгжүүлэн төмрийн хүдрийн 2 уурхай нээж, уурхайнууд дээр хуурай соронзон баяжуулах үйлдвэрүүд, гангийн үйлдвэрийн дэргэд нойтон баяжуулах үйлдвэр, ган бөмбөлгийн үйлдвэр зэргийг дэд бүтцийн ажлуудын /төмөр зам, авто зам, ачиж буулгах терманалууд, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд/ хамт барьж байгуулсан.

Төслийн 2-р шатанд 600 мян. шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, 400 мян.тн гангийн шинэ үйлдвэр байгуулах ажлууд Концессын гэрээнд зааснаар 2014-2018 онд хэрэгжүүлж дуусах байсан боловч хугацаандаа биелээгүй.

Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, шинэ гангийн үйлдвэр байгуулах хөрөнгө оруулалтын зардал өндөр /1.2 тэрбум ам.доллар/, цахилгаан эрчим хүчний хэрэглээ их / 170 МВт/, ойрын үед Дарханы шугам сүлжээ энэ хэрэглээг шийдэх боломжгүй зэрэг шалтгааны улмаас үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Иймээс төслийг хэрэгжүүлэгч “Кью Эс Си” ХХК нь хөрөнгө оруулалт багатай /700 сая ам.доллар/, цахилгаан эрчим хүчний зардал бага /75-80 МВт/ уламжлалт домен зуухний технологийг сонгон ширэм, ган үйлдвэрлэх ТЭЗҮ-ийг шинээр хийлгэж байгаа ба бүтээн байгуулалтын ажлыг 2021 онд эхлүүлж 2024 онд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар **74.83** хувьтай, **3.74** оноогоор дүгнэгдлээ.

#### УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан:  
ХШҮДАГ-ын дарга



Ц.Одхүү

Танилцуулга боловсруулсан:  
ХШҮДАГ-ын ахлах шинжээч



Х.Цэнд-Аюуш /2021.03.25/



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
НАРТАЙ 2020 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ  
/2020 оны жилийн эцсийн байдлаар/**

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 21 аймгийн Засаг дарга нартай 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ 71.4 хувьтай. /хүснэгт-1/

**Аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран  
ажиллах гэрээний үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээ**

| №              | Аймгийн нэр | Засаг даргын нэр | Гэрээний дугаар | Заалтын тоо | Дүгнэсэн арга хэмжээний биелэлтийн хувь |            |           |           |           |           |            | Биелэлтийн хувь |
|----------------|-------------|------------------|-----------------|-------------|---|------------|-----------|-----------|-----------|-----------|------------|-----------------|
|                |             |                  |                 |             | 100                                     | 90         | 70        | 50        | 30        | 0         | -          |                 |
| 1              | Архангай    | Д.Золжаргал      | 1               | 21          | 2                                       | 2          | 3         | -         | -         | -         | 14         | 84.2            |
| 2              | Баян-Өлгий  | Д.Бауыржан       | 2               | 24          | 1                                       | 6          | 5         | 3         | 1         | 2         | 6          | 65.0            |
| 3              | Баянхонгор  | Д.Мөнхсайхан     | 3               | 26          | -                                       | 6          | 3         | 7         | 3         | 1         | 6          | 59.5            |
| 4              | Булган      | Б.Ариун-Эрдэнэ   | 4               | 24          | 2                                       | 3          | 4         | 1         | -         | 1         | 13         | 72.7            |
| 5              | Говь-Алтай  | О.Амгаланбаатар  | 5               | 23          | -                                       | 4          | 2         | 7         | -         | -         | 10         | 65.3            |
| 6              | Говьсүмбэр  | Г.Батзам         | 6               | 25          | -                                       | 3          | 10        | 1         | 4         | -         | 7          | 63.3            |
| 7              | Дархан-Уул  | Б.Азжаргал       | 7               | 25          | 2                                       | 13         | 2         | 1         | 1         | -         | 6          | 83.6            |
| 8              | Дорноговь   | О.Батжаргал      | 8               | 26          | 1                                       | 11         | 4         | 3         | -         | 2         | 5          | 72.3            |
| 9              | Дорнод      | М.Бадамсүрэн     | 9               | 24          | 1                                       | 8          | 5         | 5         | -         | -         | 5          | 74.7            |
| 10             | Дундговь    | Ц.Мөнхбат        | 10              | 23          | 2                                       | 8          | 7         | -         | -         | 1         | 5          | 78.3            |
| 11             | Завхан      | Д.Түвшинжаргал   | 11              | 24          | 1                                       | 8          | 4         | 3         | 2         | 1         | 5          | 68.9            |
| 12             | Орхон       | С.Батжаргал      | 12              | 26          | 1                                       | 10         | 8         | 3         | -         | -         | 4          | 77.7            |
| 13             | Өвөрхангай  | А.Ишдорж         | 13              | 23          | 1                                       | 7          | 5         | 1         | -         | 3         | 6          | 66.4            |
| 14             | Өмнөговь    | Р.Сэддорж        | 14              | 25          | 2                                       | 6          | 5         | 4         | 1         | 1         | 6          | 69.4            |
| 15             | Сүхбаатар   | М.Идэрбат        | 15              | 24          | 1                                       | 5          | 4         | 1         | 1         | 1         | 11         | 70.0            |
| 16             | Сэлэнгэ     | Ш.Оргил          | 16              | 24          | -                                       | 8          | 2         | 4         | 2         | -         | 8          | 70.0            |
| 17             | Төв         | Д.Мөнхбаатар     | 17              | 25          | -                                       | 15         | 4         | 4         | -         | -         | 2          | 79.5            |
| 18             | Увс         | Ч.Чимэд          | 18              | 24          | 1                                       | 11         | 4         | 2         | 2         | -         | 4          | 76.5            |
| 19             | Ховд        | Б.Дүгэржав       | 19              | 23          | 1                                       | 6          | 5         | 4         | 2         | 1         | 4          | 65.7            |
| 20             | Хөвсгөл     | Л.Ганболд        | 20              | 23          | -                                       | 4          | 4         | 1         | 2         | 1         | 11         | 62.5            |
| 21             | Хэнтий      | Ц.Идэрбат        | 21              | 24          | 3                                       | 7          | 1         | 3         | 2         | -         | 8          | 75.6            |
| Үнэлгээний дүн |             |                  |                 | <b>506</b>  | <b>22</b>                               | <b>151</b> | <b>91</b> | <b>58</b> | <b>23</b> | <b>15</b> | <b>146</b> | <b>71.4</b>     |

## ДҮГНЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 21 аймгийн Засаг дарга нартай нийт 506 заалт бүхий гэрээ байгуулснаас үр дүнтэй хэрэгжсэн 22 заалт, тодорхой үр дүнд хүрсэн 242 заалт, эрчимжүүлэх шаардлагатай 81 заалт, үр дүнгүй 15 заалт, хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй 146 заалт байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт нийт дүнгээр 71.4 хувийн хэрэгжилттэй дүгнэгдлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Тухайн аймагт геологи, уул уурхай, газрын тос болон хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэхээс хамааран аймгийн үндсэн чиглэл, хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан хамтран ажиллах гэрээг боловсруулаагүйгээс ихэнх аймгуудад гэрээний дараах заалтууд хэрэгжээгүй байна.

Үүнд: Үйлдвэрийн зориулалттай тэсрэх материалын үйлдвэр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахыг батлагдсан зураг төслийн дагуу бариулж, стандарт, шаардлагыг хангуулах, аянга зайлуулагчийн эсэргүүцлийг тогтмол хэмжүүлэх зэрэг ажлыг орон нутагт зохион байгуулах, тогтоогдсон аюулгүй бүсэд газар олгохгүй байх;

Монгол Улсын хөгжлийн төлөвлөлттэй уялдуулж шинжлэх ухааны судалгаанд үндэслэн төрөөс тогтоосон солбицол бүхий ашигт малтмал эрэх хайх талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн саналд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуг хугацаанд өгөх;

Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал, газрын тосны олборлолт эрэл, хайгуул, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж байгаа бол ашигт малтмал, газар, гэрээлэгч компаниудтай зохион байгуулах уулзалтад оролцох, хамтран зохион байгуулах;

Орон нутагт газар олголтыг зохион байгуулахдаа хүнд үйлдвэр байгуулах боломжит байршлыг урьдчилан төлөвлөж, газрыг нөөцөд авах, шаардлагатай тохиолдолд газрыг тусгай хэрэгцээнд авах асуудлаар холбогдох хууль журмын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

Түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн хөдөлгөөний мэдээллийг Ашигт малтмал газрын тосны газрын чиглэл хариуцсан нэгжид улирал бүр ирүүлэх;

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулах үйлдвэрүүдийн ерөнхий мэдээллийг хагас жил тутам буюу тухайн жилийн 07 дугаар болон 12 дугаар сарын эхний хагаст багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх;

Орон нутгийн онцлог, давуу талд тулгуурласан эдийн засаг нийгэмд бодит хувь нэмэр оруулах, боловсруулах үйлдвэр байгуулах боломжийн талаар судалгаанд суурилсан санал боловсруулж, 2 дугаар улиралд багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх зэрэг заалтууд болно.

2. Хамтран ажиллах гэрээг тайлагнахдаа тухайн заалтад хамааралгүй арга хэмжээг бичих, тоо баримт, огноо, газар нутаг болон аж ахуйн нэгж, байгууллагын нэр зэргийг

дурдаагүй, бүрэн гүйцэд тайлагнаагүйгээс хийж гүйцэтгэсэн ажлын цар хүрээ харагдахгүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна.

3. Зарим заалтыг тодорхой томъёолоогүйгээс тайлагнах боломжгүй эсвэл тухайн заалтыг өнгөрсөн цаг дээр хуулбарлан тайлагнах тохиолдлууд байна.

4. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахал гарсантай холбогдуулан сургалт, уулзалт зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаагүй, мөн “үр дүнгүй” буюу 0 хувь хэрэгжилттэй заалтууд олон байгаа тул цаашид цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан бодитой төлөвлөж, гэрээний заалтыг аймаг тус бүрийн онцлогт тохируулан боловсруулах шаардлагатай байна.

#### САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Тухайн аймагт геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эсэхийг харгалзан хөгжлийн зорилтот хөтөлбөр, үндсэн чиглэл болон төлөвлөгөөтэй уялдуулан, онцлог нь тохирсон зүйл заалт бүхий “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулах,

2. Аймгууд “Хамтран ажиллах гэрээ”-ний биелэлтэд ач холбогдол өгч, гэрээний заалт бүрээр хийсэн ажлыг оновчтой, тодорхой, огноо, дугаартайгаар үнэн зөв гаргаж хэвших,

3. Гэрээний заалтад хамааралгүй болон дутуу биелэлт бичих, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах,


4. Тухайн зорилт, арга хэмжээний гол үр дүн, хүрсэн түвшин, төлөвлөсөн асуудалтай уялдуулж ажлаа тайлагнахад анхаарч ажиллах,

5. Гэрээнд тухайн бүс нутагт тухайн орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай, боломжтой бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан ажлуудыг тусгах.

Хянасан:  
ХШҮДАГ-ын дарга

ХШҮДАГ-ын ахлах шинжээч

Үнэлгээ хийж, тайлан боловсруулсан:  
ХШҮДАГ-ын мэргэжилтэн



Ц.Одхүү

Х.Цэнд-Аюуш

Н. Энхсайхан Ж.Энхсайхан



## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.

2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан.

Тус журмын 6 дугаар хэсэгт заасны дагуу хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх 3 зорилтын 8 үйл ажиллагаа, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 4 зорилтын 6 үйл ажиллагаа, нийт 12 шалгуур үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээг өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг **100%**-тай дүгнэв.

Яамны 2020 оны төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулах, хоол унааны нэмэгдлийн төсвийг батлуулж хэрэгжүүлсэн байна.

### ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

/2020 оны жилийн эцсийн байдлаар/

| д/д                                  | Үйл ажиллагаа  | №      | Шалгуур үзүүлэлт                        | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар   | Үнэлгээ |
|--------------------------------------|--|--------|---|-----------------|---------------|---|---------|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх |  |        |   |                 |               |   |         |
| 1                                    | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1    | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 0               | 75            | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны сургалтын төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 10 нд Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | 100     |
|                                      |  | Үүнээс | Ажлын байран дахь сургалт               | 0               | 28            |   |         |
|                                      |  |        | Мэргэшүүлэх сургалт                     | 0               | 5             |   |         |
|                                      |  |        | Туршлага солилцох арга хэмжээ           | 0               | 0             |   |         |
|                                      |  |        | Бусад                                   | 0               | 47            |   |         |
|                                      |  | 1.2.   | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:     | 0               | 78            |   | 100     |
|                                      |  | Үүнээс | Эмэгтэй албан хаагч                     | 0               | 12            |   |         |
| Эрэгтэй албан хаагч                  | 0  |        | 36                                      |                 |               |   |         |

|   |   |        |  |             |                           |  |     |
|---|---|--------|--|-------------|---------------------------|--|-----|
|   |   |        | Удирдах албан тушаалтан  | 0           | 19                        |  |     |
|   |   |        | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан  | 0           | 29                        |  |     |
|   |   | 1.3.   | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдэд эзлэх хувь           | 90-ээс дээш | 78 хүн давхардсан тоогоор |  | 100 |
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1.   | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо  | -           | 1 хүн 10.7 сая төгрөг     | Гадаад сургалтад хамрагдаагүй шалтгаан Ковидын тухай хууль болон улсын онцгой комиссын шийдвэр хэмнэлтийн горимд ажиллах шийдвэрээр нэмэгдэх сургалт байхгүй | /-/ |
|   |   | 2.2.   | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:  | -           | -                         |  | /-/ |
|   |   | Үүнээс | Эмэгтэй албан хаагч  | -           | -                         |  |     |
|   |   |        | Эрэгтэй албан хаагч  | -           | -                         |  |     |
|   |   |        | Удирдах албан тушаалтан  | -           | -                         |  |     |
|   |   | 2.3.   | Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь                   | 20-оос дээш | -                         |  | /-/ |
| 3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн                           | 3.1.   | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | -           | 11.1                      |  | 100 |
|   |   | 3.2.   | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь  | 15-аас доош | Шилжсэн 3                 |  | 100 |

|  |  |      |  |             |                                    |   |            |
|--|--|------|--|-------------|------------------------------------|---|------------|
| <b>Үнэлгээний дүн</b>                    |  |      |  |             |                                    |   | <b>100</b> |
| Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах |  |      |  |             |                                    |   |            |
| 4  | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх               | 4.1  | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь            | -           | 47,5 хувь                          | ТНБД-ын 2020 оны 11 сарын 4-ны өдрийн А/118   | 100        |
|  |  | 4.2  | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)                                     | -           | Хоногт хоол 8000, унаа 4000 төгрөг |   | 100        |
| 5  | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх               | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл хэнамж) | ᠙0-аас дээш | Ханамжтай                          | 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар ямар нэгэн өргөдөл, гомдол гараагүй. | 100        |
| 6  | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх          | 6.1  | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)   | 1-ээс дээш  | 1 удаа                             | Сөүл эмнэлэг 2020.12 сард   | 100        |
|  |  | 6.2  | Албан хаагчдын хамрагдалт  | ᠑0-ээс дээш | Нийт 78 албан хаагч                |   | 100        |
| 7  | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1  | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)                         | -           | 165.2                              | Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар хэсгийн 6.1.2-6.1.4 хүртэл                       | 100        |
| <b>Үнэлгээний дүн</b>                    |  |      |  |             |                                    |   | <b>100</b> |
| <b>Үнэлгээний нийт дүн</b>               |  |      |  |             |                                    |   | <b>100</b> |

### **Дүгнэлт**

#### **Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын хүрээнд:**

- Монгол Улсын Засгийн газрын 2020 сны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар шинэчлэгдсэн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2020 оны биелэлт зорилтот түвшиндээ хүрсэн тул 100 оноогоор үнэлэв.



## Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд:

- Ажиллагсдын цалин хөлс, урамшуулал, ажлын байрны нөхцөл, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах ажил зохих түвшинд хангагдсан тул 100 оноогоор үнэлэв.

### **Санал, зөвлөмж**

- Цаашид хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын зорилтот түвшинг тодорхой болгон тайлагнах, яамны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэхэд алба хаагчдын оролцоог ханган, саналыг тусгаж хэвших, хэрэгжилтийг тайлагнах, мэдээллээр хангах талаар тодорхой арга хэмжээг авах.
- Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар хэрэгжүүлсэн ажил, түүний хэрэгжилт, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажлын тайлан, үр дүнгийн талаар тодорхой биелэлт гаргах.
- Биелэлтийг тоо баримт, огноотой нотлох баримтын шаардлага хангуулан тайлагнах.

Хянасан:  
ХШҮДАГ-ын дарга  Ц.Одхүү

Үнэлгээ хийж тайлан боловсруулсан:  
Ахлах шинжээч  Х.Цэнд-Аюуш /2021.03.22/